

1. Ойн мэргэжлийн байгууллагуудыг магадлан итгэмжлэлд хамруулах шаардлага

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хамтран хэрэгжүүлж буй "Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" хөтөлбөрийн хүрээнд ойн менежментийг сайжруулахад чухал үүрэгтэй ойн магадлан итгэмжлэлийн системийг манай улсад нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ.

Ойн магадлан итгэмжлэл гэдэг нь ойн тогтвортой менежементийг сайн дурын үндсэн дээр ойн мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор нэвтрүүлж, түүнээсээ зах зээлд чанартай модон болон ойн дагалт бүтээгдэхүүн нийлүүлэх цогц механизм юм.

Дэлхийн хүн амын 5 хүн тутмын нэг нь буюу 2 тэрбум хүний аж амьдралын эх үүсвэр нь ой болон ойн эмзэг нарийн экосистемийн орчинтой шууд хамааралтай байна. Иймээс ойн үр ашгийг байнга тууштай ашиглахын тулд ойг хамгаалж, тогтвортой менежмент явуулах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Ойн магадлан итгэмжлэл нь ойн тогтвортой менежментийн баталгаа болж байдаг. Ойн тогтвортой менежмент нь урт хугацааны үйл явц түүний эерэг үр дүнг 10-аас доошгүй жилийн дараа л үзэх боломжтой юм. Ойн магадлан итгэмжлэл нь ойн санг эзэмшигчдэд өөрийн эзэмшлийн ойдоо тохирсон сайн менежментийг бие даан хариуцлагатай гүйцэтгэх боломжийг олгодог.

Манай улсын хувьд эхний ээлжинд ойн мэргэжлийн байгууллагуудад тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тавих шаардлагыг өндөрсгөх замаар тэдгээрийн хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, модон болон ойн дагалт бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, улмаар олон улсын стандартад нийцүүлэх явдал юм. Дараагийн шатанд тэдний эзэмшлийн ойн талбайд олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн ойн сангаас өндөр чанартай баталгаат модон болон ойн дагалт бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх шаардлага тавигдаж байна.

2. Ойн магадлан итгэмжлэлд хамрагдсан ойн мэргэжлийн байгууллагад хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх шаардлага

1980-1990 онд ой модны салбар эрчимтэй хөгжиж, нийгмийн нийт бүтээгдэхүүний 10 орчим хувийг үйлдвэрлэж байжээ. Энэ үед бэлтгэж ашиглах модны хэмжээ эрс нэмэгдэж 2.3 сая шоо метрт хүрч байсан байна. 1990-ээд оноос манай улс зах зээлийн харилцаанд шилжсэн, өмч хувьчлалыг буруу явуулсан зэрэг шалтгаанаар мод бэлтгэх, боловсруулах томоохон аж ахуйнууд задарч, 500 гаруй жижиг аж ахуйн нэгж болжээ.

Аж ахуйн нэгж, байгууллагууд жижгэрсэн, техник технологийн хоцрогдлын улмаас тэдгээрийн бэлтгэж ашиглах модны хэмжээ аажим буурсаар 1999-2009 онд жилд дундажаар 500.0 мянган шоо метр болжээ.

Гэвч энэ үед аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн бодит хэрэгцээг нэмэгдэж байсан хэдий ч үүнийг үл харгалзан яамнаас мод бэлтгэлийн хэмжээг эрс бууруулах бодлого барьж ирсэн нь хууль бусаар мод бэлтгэх явдлыг нэмэгдүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлжээ. Тухайн үед Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар аж ахуйн нэгж, иргэд 1.0 сая шоо метр орчим модыг хууль бусаар бэлтгэж байсан гэсэн мэдээ бий.

Харин 2011 оноос бэлтгэх модны хэмжээг ойролцоогоор 1.0 сая орчим шоо метрийн хэмжээнд барьж, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойд цэвэрлэгээний огтлолт хийх замаар үйлдвэрлэлийн болон хэрэглээний модны хэрэгцээг хангаж ирлээ.

Дээрхи байдлаас дүгнэлт хийж үзэхэд манай мод бэлтгэх ойн мэргэжлийн байгууллагууд техник технологийн хувьд хоцрогдсон, зарим томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд ОХУ-ын хуучин машин механизмыг ашигладаг, ихэнх жижиг аж ахуйн нэгжүүд мод цагаалах, ачих, буулгах ажлыг гараар гүйцэтгэдэг, модыг сортиментаар тээвэрлэдэг зэрэг шалтгаанаас ойг зөв зохистой ашиглах ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээл учруулж байна.

Иймээс ойн магадлан итгэмжлэлийг ойн салбарт нэвтрүүлэхэд эхний ээлжинд өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчин, техник технологи, эзэмшлийн талбайн ойн менежментийн түвшинг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид өнөөгийн түвшинг аажмаар дээшлүүлэх, магадлан итгэмжлэлийг жинхэнэ утгаар олон улсын хэмжээнд хүргэхийн тулд ойн мэргэжлийн байгууллагуудад дараахи хөнгөлөлт, урамшууллыг үзүүлэх нь зүйтэй юм.

Ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-аас 2016 оны 2 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 10-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал сум, Тунхэл тосгон, Алтанбулаг, Ерөө сумын Бугант тосгон, Орхон аймаг, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Хөвсгөл аймгийн Мөрөн, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон, Цагаан-Үүр, Эрдэнэбулган зэрэг сумын 24 ойн мэргэжлийн байгууллага, Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар, Ерөө, Цагаан-Үүр, Хялганатын Ойн ангиудад ажиллав.

Энэ хугацаанд Байгаль орчны газар, Ойн ангиуд, ойн мэргэжлийн байгууллагын ажилтнуудад олон улсын ойн магадлан итгэмжлэл, түүний зорилго, монголд хэрэгжүүлэх боломж, Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын үйл ажиллагааны талаар ярьж, тэдний магадлан итгэмжлэлийн талаархи санал бодлыг сонсов.

Мөн түүнчлэн үйлдвэрлэлийн болон арчилгаа цэвэрлэгээний ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд Герман улсын зөвлөх Лютц Хофхайнзтай хамтран боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийг туршиж, магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагуудад үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын талаар тэдгээрийн санал бодлыг авч нэгтгэв.

Ойн мэргэжлийн байгууллагуудын ажилтнуудаас гарсан саналуудыг нэгтгэж үзвэл банк, санхүү, хөрөнгө оруулалт, гааль татварын хөнгөлөлт үзүүлэх, ойн менежментийг боловсронгуй болгох, ойн үйлдвэрлэлийг дэмжих, сургалт, сурталчилгаа явуулах гэсэн 5 чиглэлээр хөнгөлөлт, урамшууллын арга хэмжээ авахыг хүссэн байна.

1.Банк, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх

Ойн мэргэжлийн байгууллагууд санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан техник технологийн шинэчлэл хийж чадахгүй байна. Иймээс магадлан итгэмжлэгдсэн ААН-д Банк, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх сан байгуулах, урт хугацаанд хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг Аж үйлдвэрийн болон БОНХАЖЯ хамтран боловсруулж шийдвэрлүүлбэл магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагуудад техник технологийн шинэчлэл хийх боломж бүрдэнэ.

2.Гааль, татварын хөнгөлөлт үзүүлэх

Ойн мэргэжлийн байгууллагууд үйлдвэрлэл явуулах, техник тоног төхөөрөмж, материал худалдаж авах, бүтээгдэхүүн гаргахад төрөл бүрийн татварууд бэрхшээл учруулдаг тул Гааль, НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг Аж үйлдвэрийн болон БОНХАЖЯ хамтран боловсруулж шийдвэрлүүлэх шаардлагатай.

3.Ойн менежмент, төлөвлөлтийг боловсронгуй болгох

Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг амьдралд хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө байхгүйгээс ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлын цар хүрээ, үр дүн хангалтгүй байгаа билээ. Ойг хамгаалах, зохистой ашиглах,

итгэмжлэгдсэн ААН-ийг татан оролцуулснаар ААН-ийн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх. Магадлан итгэмжлэгдсэн ААН-д ойн санг давуу эрхээр эзэмшүүлэх, менежментийн төлөвлөгөөнд тусгасан Ойн аж ахуйн арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх эрх олгох, Олон улсын төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

4.Магадлан итгэмжлэгдсэн ААН-ийн давуу эрх олгох, Ойн үйлдвэрлэлийг дэмжих

Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад улс, аймаг, сумын түвшинд үзүүлэх дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай. Тухайлбал улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх Ойн аж ахуйн арга хэмжээнд зөвхөн магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудыг оролцуулах, эсхүл давуу эрхтэй байх боломжийг бүрдүүлэх. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод бэлтгэх эрх олгох, ойн санг гэрээгээр эзэмшүүлэх, ойн бирж байгуулах зэрэг асуудлыг аймаг, сумын түвшинд, ойн зам засах, дэд бүтцийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх зэрэг томоохон ажлыг яамны түвшинд тус тус шийдвэрлэх нь зүйтэй юм.

5.Сургалт, сурталчилгаа явуулах

Ойн мэргэжлийн байгууллагуудад мэргэжилтэй боловсон хүчний хангамж муу, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний сурталчилгаа, мэдээлэл хангалтгүй байна. Иймээс ойн мэргэжлийн байгууллагуудын үйлдвэрлэж байгаа модон болон ойн дагалт бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, ажилчдыг сургах, дадлагажуулах ажилд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Ойн магадлан итгэмжлэлд хамрагдсан ойн мэргэжлийн байгуулагад үзүүлэх, хөнгөлөлт, дэмжлэг, урамшууллын арга хэмжээний төслийг дор хавсаргав.

ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД ХАМРАГДСАН ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨЛ

| | Хөнгөлөлт урамшууллын хэлбэр, арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хариуцах байгууллага | Хугацаа, | Гарах үр дүн |
|--|--|---|----------------------------|--------------|---|
| Нэг.Банк, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх | | | | | |
| 1 | Банкны зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх | Хуулийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх | Аж үйлдвэрийн яам, БОНХАЖЯ | 2016-2017 он | Ойн мэргэжлийн байгууллагуудад техник технологийн шинэчлэл хийх боломж бүрдэнэ. |
| 2 | Урт хугацааны зээл авах | | | | |
| 3 | Урт хугацааны хөрөнгө оруулалтын сан бий болгох | | | | |
| 4 | Лизингийн тоног төхөөрөмжийн сан байгуулах, бүрдүүлэх, лизингээр тоног төхөөрөмж олгох | | | | |
| Хоёр.Гааль татварын хөнгөлөлт үзүүлэх | | | | | |
| 5 | НӨАТ хөнгөлөлт үзүүлэх | Хуулийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх | Аж үйлдвэрийн яам, БОНХАЖЯ | 2016-2017 он | Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, бараа бүтээгдэхүүн борлуулах ажилд ахиц гарна |
| 6 | Гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх | | | | |
| 7 | Импортын давуу эрх эдлэх | | | | |
| 8 | Экспортын давуу эрх | | | | |

| | | | | | |
|--|--|---|-----------------------------------|--------------|---|
| | дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | тогтоолын төсөл боловсруулах | АҮЯ | он | менежмент бий болж, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлын үр дүн дээшилнэ. |
| 10 | Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг магадлан итгэмжлэгдсэн ААН-ийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, магадлан итгэмжлэгдсэн ААН-ийг урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх. | Санал боловсруулах | БОНХАЖЯ, аймаг, сумын удирдлага | 2016-2017 он | Ойн мэргэжлийн байгуулагуудын үйл ажиллагаа жигдэрнэ. |
| 11 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх Ой аж ахуйн арга хэмжээг магадлан итгэмжлэгдсэн ААН-ээр гүйцэтгүүлэх. | Худалдан авах | | | |
| 11 | Гадаад орнуудад ойн менежментийн туршлага судлах | Санал боловсруулах | БОНХАЖЯ, АҮЯ ОУ-ын төсөл хөтөлбөр | Тухай бүр | Ойн менежментийн тухай ойлголт сайжирна. |
| 12 | Ойн менежментийн чиглэлийн төсөл хөтөлбөрт хамруулах | Санал боловсруулах | БОНХАЖЯ, АҮЯ ОУ-ын төсөл хөтөлбөр | Тухай бүр | Ойн менежментийн үйл ажиллагаанд ахиц гарна. |
| Дөрөв. Ойн үйлдвэрлэлийг дэмжих | | | | | |
| | Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолд “Магадлан итгэмжлэгдсэн мод модон бүтээгдэхүүн” | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах | | | |
| 13 | Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад ойн санг давуу эрхтэйгээр эзэмшлүүлэх | Санал боловсруулах | аймаг, сумын удирдлага | 2016-2017 он | Ойн мэргэжлийн байгуулагуудын үйл ажиллагаа жигдэрч, ойн менежмент сайжирна. |
| 14 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг давуу эрхээр гүйцэтгэх | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил | АҮЯ, БОНХАЖЯ | Жил бүр | Ойн мэргэжлийн байгуулагуудын үйл ажиллагаанд дэмжлэг болно. |

| | | | | | |
|--|--|---|--------------------------------------|-----------|---|
| | | нэмэлт өөрчлөлт оруулах | | | |
| 15 | Ойн бүтээгдэхүүн борлуулах ойн биржийг ажиллуулах | Санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ, аймаг, сумын удирдлага | Жил бүр | Модон болон ойн дагалт бүтээгдэхүүний борлуулалт сайжирна. |
| 16 | Ойн зам засах, дэд бүтцийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх | Улсын төсөвт хөрөнгө тусгах санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ | Жил бүр | Мод бэлтгэх, ойн дагалт бүтээгдэхүүн олборлох, ойн санг түймэр, хөнөөлт шавжаас хамгаалах ажилд ахиц гарна. |
| 17 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас давуу эрхтэйгээр мод бэлтгэх, боловсруулах үйлдвэр, ойг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх | Санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ | Жил бүр | Ойн мэргэжлийн байгууллагын техник технологийн хангамж сайжирна. |
| 18 | ОУ-ын ой, модны үзэсгэлэн худалдаанд давуу эрхээр оролцох | Төсөл хөтөлбөрөөс дэмжлэг авах санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ | Тухай бүр | Тэргүүний техник технологи эзэмшихэд дэмжлэг болно. |
| 19 | Ойн хаягдал гишүү мөчрийг бүрэн ашиглах, чага мөөг, самар, жимс, бусад ойн дагалт баялгийг боловсруулах техник технологийн дэмжлэг үзүүлэх | Улсын төсөвт тусгах санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ | Жил бүр | Ойн ашиглалтын түвшинг дээшилж, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно. |
| Тав.Сургалт, сурталчилгаа явуулах | | | | | |
| 20 | Магадлан итгэмжлэгдсэн ААН-ийн үйлдвэрлэсэн мод, модон болон ойн дагалт бүтээгдэхүүнийг сурталчлах | Санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ | Жил бүр | Бүтээгдэхүүний борлуулалтанд дэмжлэг болно. |
| 21 | Мод бэлтгэлийн хөрөөчин, ойжуулагч зэрэг ажилчдад мэргэжил олгох, дадлагажуулах төлбөргүй сургалтанд хамруулах | Санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ Төсөл хөтөлбөрүүд | Тухай бүр | Ажилчдын чадавхи сайжирна. |
| 22 | Ойн менежментийн тухай сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах | Санал боловсруулах | АҮЯ, БОНХАЖЯ Төсөл хөтөлбөрүүд | Тухай бүр | Ойн менежментийн тухай ойлголт сайжирна. |